



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/376

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалаар баталсан журмын 2 дугаар зүйлийн 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулах үеэр сонгуулийн хэсгийн хороодод зайнаас халуун хэмжихээр нийлүүлсэн халуун хэмжигчийн үнэ 5 151 000 төгрөг /таван сая нэг зуун тавин нэгэн мянган/-ийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Тус арга хэмжээнд зарцуулах 5 151 000 төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.


3. Сонгуулийн хэсгийн хороодод ашигласан халуун хэмжигчийг олгосон сумдын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгүүлж, ашиглахыг аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Ц.Мягмарсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны
07 дугаар сарын 08-ны өдрийн
А/376 дугаар захирамжийн хавсралт



ХЭСГИЙН ХОРООДОД ЗАЙНААС ХАЛУУН ХЭМЖИХЭЭР
НИЙЛҮҮЛСЭН ХАЛУУН ХЭМЖИГЧИЙН ҮНЭ

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Нийт үнэ /мянган төгрөгөөр/
1.	Зайнаас халуун хэмжигч	ш	34	150000.00	5100.0
2.	Батерей	ш	34	1500.00	51.0
	Дүн				5151.0

-оОо-